



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Үнэт цаасны бүртгэлд  
өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 07-р сарын 07-ны өдрийн 273 тоот тогтоол, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11-р заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Бүртгэлийн журам”-ын 20 дугаар зүйлийн 20.1, 20.2.1, 20.3-р заалт, “Даваанбулаг” хувьцаат компанийн 2014 оны 08-р сарын 14-ний өдрийн 79 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу хийсэн бүртгэлийн шалгалтын тайлан, 2014 оны 08-р сарын 19-ний өдрийн захирлын зөвлөлийн хурлын санал, дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Даваанбулаг” хувьцаат компанийн гаргасан нийт 103,703 /нэг зуун гурван мянга долоон зуун гурав/ ширхэг энгийн хувьцаанаас 69,066 /жаран есөн мянга жаран зургаа/ ширхэг хувьцааг хасч, хувьцааны тоог 34,637 /гучин дөрвөн мянга зургаан зуун гучин долоо/ ширхэг болгон бүртгэлд өөрчлөлт оруулсугай.
- Холбогдох мэдээллийн санд өөрчлөлт оруулж, “Үнэт цаасны төлбөр, тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” хязгаарлагдмал хариуцлагатай компанийд мэдэгдэл хүргүүлэн, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Бүртгэлийн гэрээ”-г “Даваанбулаг” хувьцаат компанийтай шинэчлэн байгуулахыг Үйл ажиллагааны газар /М.Энхтуяа/-т үүрэг болгосугай.
- “Даваанбулаг” хувьцаат компанийн хувьцааны бүртгэлд өөрчлөлт орсон тухай мэдээллийг олон нийтэд хүргэхийг Зах зээлийн хөгжлийн газар /Ж.Мягмарсүрэн/-т үүрэг болгосугай.
- Монгол Улсын үнэт цаасны зах зээл дээр мөрдөгдөж буй хууль тогтоомж, журам зааврыг үйл ажиллагаандaa чанд мөрдөж, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийтай байгуулсан “Бүртгэлийн гэрээ”-гээр хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллахыг “Даваанбулаг” хувьцаат компани /Ж.Мөнхбаяр/-т үүрэг болгосугай.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Д. АНГАР

Маягт 5

ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО,  
ХАДГАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГАД  
ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ

Хэнд: "Үнэт цаасны төлбөр тооцоо,  
төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-д

№ 150

Огноо: 2014.08.19

ҮЗҮҮЛЭЛТ	БҮРТГЭГДСЭН БАЙДАЛ	БҮРТГЭЛД ОРОХ ӨӨРЧЛӨЛТ
Мэдэгдлийн агуулга:	Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай	
Үндэслэл:	Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 07-р сарын 07-ны өдрийн 273 тоот тогтоол, МХБ-ийн гүйцэтгэх захирлын 2014 оны 08-р сарын 11 –ний өдрийн №12 тоот тушаал	
Санхүүгийн хэрэгсэл:	Хувьцаа	Хувьцаа
Үнэт цаасны нэр:	"Даваанбулаг" ХК	"Даваанбулаг" ХК
Үнэт цаасны код: /үсгэн, тоон/	DBL	DBL
Үнэт цаасны төрөл: /энгийн, давуу эрхийн/	Энгийн	Энгийн
Үнэт цаасны хэлбэр: /биет, биет бус/	Биет бус	Биет бус
Нийт үнэт цаасны тоо: /ширхэг/	103,703	34,637
Энгийн	тоо /ширхэг/	103,703
	хувь %/	100%
Олон нийтийн Эзэмшил	тоо /ширхэг/	103,703
	хувь %/	100%
Төрийн эзэмшил	тоо /ширхэг/	-
	хувь %/	-
Үнэт цаасны нэрлэсэн үнэ: /төгрөг/	100	100
Үнэт цаасны нийт үнийн дүн: /төгрөг/	10,370,300	3,463,700

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Д.АНГАР

